



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 04

Эрдэнэт

“Чөлөөт цагийн талбай” дэд хөтөлбөр,
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Чөлөөт цагийн талбай” аймгийн дэд хөтөлбөрийг нэгдүгээр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусгах, хөтөлбөрийн явц, үр дүнг жил бүрийн 1 дүгээр сард аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнахыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д даалгасугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА